

**Өвөрхангай аймгийн ТЕЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлбар.**

Санхүүгийн нэгдсэн тайлангаар Өвөрхангай аймгийн орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2014 оны санхүүгийн байдал, үр, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн гаргасан.

**Санхүүгийн тайлангийн хамрах хугацаа:** 2014 оны 01 сарын 01 нээс 2014 оны 12 сарын 31 өдөр.

**Үндэслэл:** Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудыг үндэслэж стандартуудын зарчмын дагуу санхүүгийн байдал, үр дүнгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккурелль сууриар мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг ашиглан бэлтгэсэн.

Санхүүгийн жилийн орлого нь тухайн жилийн батлагдсан төсвийн дагуу орон нутгийн татварын ба татварын бус орлого, батлагдсан төсвийн дагуу дээд шатны төсвийн захирагчаас авсан санхүүгийн дэмжлэг, үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлого, хандив тусламжийн мөнгөн ба мөнгөн бус орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэв.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд PLASTIC 3.0 программ болон onlain хэлбэрийн Э-Тайлангийн нэгтгэлийг тус тус ашигласан. Нэгдсэн тайланг дээрхи тайлагналын 2 системээр тус тусд нь зэрэгцүүлэн гаргасан

Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн нэгдсэн тайланг 2015 оны 04 сарын 01 нд Аудитийн байгууллагад хүргүүлж салбар, багц бүлгүүдээр болон нэгдсэн дүгнэлт гаргуулсан.

**Санхүүгийн нэгдсэн тайланд** ТЕЗ-ийн харъяалалын 19 сумын болон аймгийн төвийн нийт 20 төрийн сан, орон нутгийн 119 төсвийн байгууллага, 72 төсөл сан, тусгай шилжүүлгийн нийт 125 байгууллага, ОНӨҮГ - 2 нийт 338 байгууллагын санхүүгийн байдал, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, өмчийн өөрчлөлтийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайланг нэгтгэн илэрхийлэв.

Үндсэн үйл ажиллагааны орлого болон төсвийн урсгал санхүүжилтээс бусад орлого, зарлагын гүйлгээг байгууллага бүрийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хийж, энэ орлого зарлагыг тайланг тухайн байгууллага бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилийн кодоор тайлагнасан.

Орон нутгийн нийт төсвийн орлого аймгийн дүнгээр 9219,8 сая төгрөгөөр буюу 106,6 хувиар биелэж 551,2 сая төгрөгөөр буюу 6,4 хувиар төлөвлөгөөнөөс давж биелэсэн байна.

Үүнээс : Аймагт төвлөрөх татварын ба татварын бус орлого 6988,9 сая төгрөг буюу 102,76 хувиар, суманд төвлөрөх орлого 1313,9 сая төгрөг буюу 101,79 хувиар биелэсэн байна.

Сумын орлого нийт дүнгээрээ биелэсэн боловч ноосны урамшуулалаас авах ёстой байсан ОТБИОАТ-ын орлого тасарсан байна.

Үүний улмаас санхүүжилт дутсан нийт 9 суманд 88,4 сая төгрөгийн зээлийн Орон нутгийн өмчийн сангаас эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон.

Нийт улсаас 13696,1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг / 100% / авсаны 8774,6 сая төгрөгийг сумдад санхүүгийн дэмжлэг болгон хувиарласан байна.

Орон нутгийн хөгжлийн санд улсаас 12263,9 сая төгрөг авахаас 9350,2 сая төгрөг авсан. Үүний 5733,5 саяыг сумдад хувиарлаж, 3616,7 сая төгрөгийг аймгийн ОНХСанд зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүгийн санхүүжилтээр нийт улсаас 38914,4 сая төгрөг авахаас 38910,6 сая төгрөг авсан. Үүний 6214,4 сая төгрөг нь ЭМ салбарт, 29970,2 сая төгрөг нь Боловсролын салбарт, 227,5 сая төгрөг нь барилга хот байгуулалтын салбарт, 159,8 төгрөг нь нийгэм хамгаалалын, 2336,0 сая төгрөг нь соёлын салбарт зарцуулсан байна.

**Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар: / Төсөвт байгууллага /**

Д / Д	Үзүүлэлт	Орон нутаг		ТЗШ		НИЙТ ДҮН	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		1572175,9		519,7		1572695,7
	Орон нутгийн санхүүжилт	23032130,7	22766085,2			23032130,7	22766085,2
	ТЗСанхүүжилт			38914415,9	38908081,8	38914415,9	38908081,8
	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	12263936,4	9350238,8			12263936,4	9350238,8
	Өөрийн орлого	257841,8	349413,7	319027,3	363641,8	576869,2	7130554
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>35553908,9</b>	<b>32465737,6</b>	<b>39233443,2</b>	<b>39271723,6</b>	<b>74787352,2</b>	<b>71737461,3</b>
	Нийт төсвийн гүйцэтгэл	35553908,9	32938468,8	39233443,2	39244117,2	74787352,2	72182586,0
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1099444,8		1008,0		1100452,8

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл авч үзэхэд 2014 онд орон нутгийн төсвийн орлого 32465737,6 мянган төгрөг, зарлага 32938468,8 мянган төгрөг, Тусгай

зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн орлогын гүйцэтгэл 39271723,7 мянган төгрөг, зарлагын гүйцэтгэл 39244117,2 мянган төгрөг, нийт төсвийн орлогын гүйцэтгэл 71737461,3 мянган төгрөг, зарлагын 72182586,0 мянган төгрөг байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлийг авч үзвэл:**

д/д	Үзүүлэлт	2013 он	2014 он	+Өсөлт, -бууралт	Тайлбар
01	Мөнгөн хөрөнгө -Дүн	1842564011	1252767831	-589796180	Буурсан
	Орон нутаг	1840360962	1251589485	-588771477	Буурсан
	ТЗШ	2203049	1178346	-1024703	Буурсан
02	Авлага ДҮН	42285167	702520606	660235439	
	Орон нутаг	7553905	617994610	610440705	ОНХО-550971530 АИТХ -1030700 бэлэг дургалын үнэ АЗДТГ-11345790 Гэр бүл хүгий хөгжил- 5151450 хоолны үнэ
	ТЗШ	34731262	84525996	49812734	ЕБС,СӨББ -ийн ОН-т төвлөрүүлсэн 27118161 төг авлагад тусгасан. ХДТ -9525371 ЕБС,СӨББ - хоол, бараамат, бусад авлага 13169000
	<b>Бараа материал ДҮН</b>	<b>3833849179</b>	<b>4121689112</b>	<b>287839933</b>	
	Орон нутаг	799140577	998342229	199201652	Нэмэгдсэн
	ТЗШ	3034708601	3123346882	88638281	Нэмэгдсэн
	<b>Үндсэн хөрөнгө ДҮН</b>	<b>87057140916</b>	<b>107485523605</b>	<b>20428382689</b>	
	Орон нутаг	30321096701	35554035399	5232938698	Худалдаж авсан 751546440, Шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээр - 4481392258
	ТЗШ	56830044207	72046415607	15216371400	Худалдаж авсан 737719111 Эрдэнэзуу дахин үнэлгээ хийсэн 6457209, Үнэ төлбөргү болон шилжүүлэн авсан -13462515310
	<b>Өглөг ДҮН</b>	<b>39026377</b>	<b>906843907</b>	<b>867817530</b>	
	Орон нутаг	31775327	661073872	629298545	Халамж-106853162 ОНХСан-550971530
	ТЗШ	7251050	245770035	238518985	

Мөнгөн хөрөнгийн 2014 оны эхний үлдэгдэл 1842,5 сая төгрөг байсан. Үүний 932,6 сая төгрөг нь аймгийн хэмжээний ОНХС -ийн үлдэгдэл, 414,8 сая төгрөг нь ОНХО-ын дансны үлдэгдэл, 281,6 сая төгрөг нь сумдын халамжийн сангийн үлдэгдэл

213,5 сая төгрөг нь төсөвт байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл байсан.

2014 онд 1252,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Үүний 819,4 сая нь ОНХО-ын дансны жагсаалт нь батлагдсан боловч тендер зарлагдаагүй, гэрээ нь байгуулагдаагүй ажлын олгоогүй санхүүжилтийн үлдэгдэл , 398,7 сая төгрөг нь ОНХС-ийн үлдэгдэл байна.

Авлагын үлдэгдэл 660,2 сая төгрөгийн 550,5 сая төгрөг нь ОНХО-ын авлага, /ОНХСангийн зарим өглөгийг ОНХО-ын данснаас олгож өр барагдуулж авлагад тусгасан. / АИТХ-ын 10307,0 мянган төгрөг , АЗДТГ-ын 11345,8 мянган төгрөг, Гэр бүл хүний хөгжлийн хэлтэс 5151,4 мянган төгрөг байна.

Нийт өглөг 906,8 сая төгрөг. Үүний 550,9 сая төгрөг ОНХС-ийн өглөг, 106,8 сая төгрөг нь Халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмжийн олгоогүй үлдэгдэл, 238,5 сая төгрөг нь ЕБС, СӨББ- ийн байгууллагын хоол, халаалт , гэрэл, бусад өглөг байна.

Боловсролын салбарын санхүүжилт төсвийн тодотголоор нийтдээ 360,0 сая төгрөгөөр хасагдсан, шинээр Уянга, Хархорин, Бат-Өлзий, Арвайрээр суманд Сургууль, цэцэрлэг ашиглалтанд орсон боловч төсөв нэмж олгоогүй зэрэг шалгаанаар өр үүссэн байна.

Бусад үзүүлэлт болох бараа материал үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос өссөн байна.

### **Санхүү, төрийн сангийн хэлтэс.**